

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2023 оны 98 дугаар тушаалын  
6 дугаар хавсралт

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Л.ИШХАНДЫН  
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/<br>д  | Зорилтыг хэрэгжүүлэх арга<br>хэмжээ   | Шалгуур<br>үзүүлэлт   | Гүйцэтгэлийн түвшин                                     |   |   |                                |                         |
|--|---|---|---|---|---|--------------------------------|-------------------------|
|  |   |   | Суурь түвшин  | Хүрэх түвшин  | Хүрсэн түвшин (биелэлт)   | Эхэлсэн,<br>дууссан<br>хугацаа | Биелэлт<br>-ийн<br>хувь |
| 1  | 2   | 3   | 4   | 5   | 6   | 7                              |                         |
| Зорилт 1. “Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг тайлагнах” зорилтын хурээнд” |   |   |   |   |   |                                |                         |
| 1.   | Арга хэмжээ 1.1<br>Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн санд байршуулах, тайлагнах | -Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан байдлаар -Хагас жил тутам тайлагнаж, баталгаажуулсан эсэх | Сар бүр нийт 12 удаа цахим санд байршуулж, тайлагнасан. | -Хяналт-шинжилгээ, үнэлгээг 6-аас доошгүй удаа хийж ажиллана.<br>-Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд тухай бүр байршуулж, баталгаажуулсан ажилласан байна. | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг сар бүрийн 10-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд байршуулан, хугацаанд нь баталгаажуулан ажиллаж байна. Нийт 16 зорилтын 18 заалт тус бүрийн биелэлтийг гарган уахим санд байршуулан ажилласан. | 1/1-12/05                      | 100.0                   |
| 2.   | Арга хэмжээ 1.2.<br>Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт, үр дүнд хяналт-  | -Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг   | Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн шалгуур | Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур   | Аймгийн хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2023 оны хэрэгжилт үр дүнгийн тайланг гаргаж, Засгийн газрын Хэрэг  | 5/1-30                         | 100.0                   |

|    |  |   |  |   |   |            |       |
|----|--|---|--|---|---|------------|-------|
|    | шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах  | ашигласан байдал<br>-Хяналт-шинжилгээ үнэлгээний дүгнэлт боловсруулж ажилласан эсэх   | явц, үр дүнг 2023 оны 6 дугаар сард аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн 70.9 хувийн хэрэгжилттэй буюу тодорхой үр дүнд хүрсэн гэж дүгнэгдсэн. | үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ хийж, үр дүнг засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна. | эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд 2024 оны эхийн улиралд тайлант хугацаанд байршуулан ажилласан. Нийт 157 заалтын хэрэгжилтийн дандаж 88.92 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнаж, 87.9 хувийн биелэлттэйгээр дүгнэгдсэн. Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт, үр дүнгийн тайланг 2024 оны 5 дугаар сард аймгийн Засаг даргын зөвлөл, аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд хэлэлцүүлж ажиллалаа. Уг бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг 87.2 хувийн хэрэгжилттэй буюу тодорхой үр дүнд хүрсэн гэж дүгнэв. |            |       |
| 3. | Арга хэмжээ 1.3.<br>Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн санд байршуулах, тайлагнах | -Хяналт-шинжилгээ хийсэн тайланг хугацаанд нь байршуулж баталгаажуулсан эсэх<br><br>-Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн тоо | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр хэлэлцэж, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга           | --  | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнг 2023 оны жилийн эцсийн байдлаар үнэлэн 2024 оны 2 дугаар сарын 1-нд Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд хугацаанд нь байршуулж ажилласан.<br>Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөрийн   | 1/01-12/03 | 100.0 |

|    |  |  |  |  |  |                            |       |
|----|--|--|--|--|--|----------------------------|-------|
|    |  |  | хэмжээний эхний 3 жилийн хэрэгжилт, үр дүнг 86.8 хувийн хэрэгжилттэй гэж дүгнэгдсэн.   |  | хэрэгжилт, үр дүнгийн тайланг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 89.2 хувийн хэрэгжилттэйгээр дүгнэгдлээ.  |                            |       |
| 4. | Арга хэмжээ 1.4.<br>Засгийн газрын гишүүнээс аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд байршуулах | -Байгуулсан гэрээний тоогоор<br>-Бүх гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийгдсэн эсэх | 2023 онд Засгийн газрын гишүүнээс аймгийн Засаг даргатай нийт 19 гэрээ хийгдэж, гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, төрийн захиргааны төв байгууллагууд ад хүргүүлэн ажилласан. | Монгол Улсын Засгийн газрын гишүүн, төсвийн ерөнхийлөн захирагч 8 сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. | 2024 оны эхний хагас жилд нийт Засгийн газрын 8 гишүүнтэй байгуулсан гэрээний биелэлтийг гэрээнд тусгагдсаны дагуу тайлагнасан бол жилийн эцсийн байдлаар нийт 19 сайдтай байгуулсан гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнаж байна. 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар нийт 5 сайдтай байгуулсан гэрээний үүргийн биелэлтэд шалгуур үзүүлэлтийг суурь болон зорилтолт түвшинтэй харьцуулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж төрийн захиргааны төв | 6/05-30<br>11/25-<br>12/20 | 100.0 |

|  |   |   |  |   |   |            |       |
|--|---|---|--|---|---|------------|-------|
|  |   |   |  | байгууллагуудад<br>хүргүүлээд байна.  |   |            |       |
| Зорилт 2. “Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэх,<br>удирдлагыг мэдээллээр хангах, зөвлөмж хүргүүлэх” |   |   |  |   |   |            |       |
| 5.   | Арга хэмжээ 2.1.<br>Аймгийн хэмжээнд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хянах, аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнг үнэлэх, мэдээлэх, тайлагнах мэдээллийн цахим санг шинээр нэвтрүүлэх | -Цахим мэдээллийн санг шинээр нэвтрүүлсэн эсэх<br><br>-Мэдээллийн сангийн ашиглаж байгаа байгууллагын тоо | --   | Цахим сангийн туршилтын үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.                                  | Аймгийн хэмжээнд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хянах, аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнг үнэлэх, мэдээлэх, тайлагнах мэдээллийн цахим санг “Очир-Ай гүүгл” ХХК-аар гүйцэтгүүлэх гэрээ байгуулан ажилласан. Уг цахим сан нь З хэсгээс бүрдэж байгаа бөгөөд цахим мэдээллийн сангийн үйл ажиллагааг эхлүүлээд байна. | 4/01-12/05 | 100.0 |
| 6.   | Арга хэмжээ 2.2.<br>Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, сумдын ЗДТГ-ын 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх  | -ХШҮ-нд хамрагдсан сумын тоо<br><br>-ХШҮ-нд хамрагдсан байгууллагын тоо                                   | Журмын дагуу 5 сум, 3 агентлагийг шалгаруулсан | ХШҮ-ний дунгээр журмын дагуу 5 сум, 3 агентлагийг журмын дагуу шалгаруулан ажилласан байна. | Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу сумдын ЗДТГазар болон аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагуудын 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэн ажилласан. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд журмын дагуу холбогдох байгууллагуудыг хамруулж, 5 сум (Бат-  | 01/02-2/05 | 100.0 |

|    |  |   |  |  |   |             |       |
|----|--|---|--|--|---|-------------|-------|
|    |  |   |  | Өлзий, Есөнзүйл, Өлзийт), 3 агентлагийг (аймгийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар) шалгаруулав. | Хархорин, Гучин-Ус, Нийгмийн  |             |       |
| 7. | Арга хэмжээ 2.3. Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын мөрөөр гүйцэтгэл сайжруулах үүрэг чиглэл өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах  | -23 агентлаг, 19 сумдад өгсөн зөвлөмж өгч ажилласан эсэх<br>-Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байдал | 23 агентлаг, 19 сумдын ЗДТГ-т зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.                          | Бүх сум, агентлагт зөвлөмж өгч ажилласан байна.  | Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын мөрөөр бүх байгууллага, сумдын Засаг даргын Тамгын газарт зөвлөмж өгч ажиллав. Зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх ажлыг байгууллагуудад ажилласан явцын хяналт-шинжилгээний үеэр хяналт тавьж ажиллаж байна.              | 01/05-12/05 | 100.0 |
| 8. | Арга хэмжээ №2.4. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас аймгийн 2023 үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлт, зөвлөмжтэй уялдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах | -Боловсруулсан төлөвлөгөөтэй эсэх<br>-Төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцон ажилласан байдал                          | 2023 онд ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжилтийн тооцон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт тайлагнасан. | Зөвлөмжийн дагуу үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан байна.   | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 01/620 дугаартай албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж Засаг даргын тамгын газрын даргаар батлуулан ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн тайланг 11 дүгээр сарын 01-ний байдлаар | 09/01-12/05 | 100.0 |

|  |   |  |   |  |   |                                |      |
|--|---|--|---|--|---|--------------------------------|------|
|  |   |  |   |  | гарган, Засгийн газрын<br>Хяналт хэрэгжүүлэх газарт<br>тайлагнасан.   |                                |      |
| 9.   | Арга хэмжээ № 2.5.<br>Сумдын ЗДТГазар болон<br>аймгийн Засаг даргын<br>дэргэдэх агентлагуудын<br>үйл ажиллагаанд явцын<br>хяналт-шинжилгээ хийж,<br>арга зүйн зөвлөмжөөр<br>хангах        | -Явцын хяналт-<br>шинжилгээ<br>хийгдсэн сумын<br>тоо<br><br>-Явцын хяналт-<br>шинжилгээ<br>хийсэн<br>байгууллагын<br>тоо | 5 сум, 3<br>агентлагийн<br>үйл<br>ажиллагаанд<br>явцын хяналт-<br>шинжилгээ<br>хийж<br>ажилласан. | 4 сум, 3<br>агентлагийн үйл<br>ажиллагаанд<br>хяналт-<br>шинжилгээ хийж. | 2 агентлагийн үйл<br>ажиллагаанд хяналт-<br>шинжилгээ хийж ажлын<br>удирдамж боловсруулагдан явцын<br>хяналт-шинжилгээг хийж,<br>арга зүйн зөвлөмж өгч<br>ажиллалаа.<br><br>Тарагт, Өлзийт зэрэг 5<br>сумын хууль эрх зүйн<br>ажилтнуудад арга зүйн<br>зөвлөмж өгч, мэргэжил<br>удирдлагаар хангаж<br>ажилласан.  | 6/15-20<br><br>10/25-<br>12/05 | 70.0 |
| 10.  | Арга хэмжээ №2.6. Улсын<br>төсөвт байгууллагууд<br>(төрийн болон орон<br>нутгийн өмчит хуулийн<br>этгээд)-ын үйл<br>ажиллагаанд хяналт-<br>шинжилгээ хийж, арга зүйн<br>зөвлөмжөөр хангах | -Хяналт-<br>шинжилгээ хийж<br>ажилласан<br>байгууллагын<br>тоогоор   | --  | --   | Засгийн газрын Хяналт<br>хэрэгжүүлэх газраас төрийн<br>болон орон нутгийн өмчит<br>үйлдвэрийн газруудын үйл<br>ажиллагаанд хяналт-<br>шинжилгээ хийж талаар<br>шинээр боловсруулагдаж<br>байгаа журамд тусгасан<br>бөгөөд журам хэрэгжиж<br>эхлэхтэй уялдуулан зохион<br>байгуулж ажиллахаар<br>төлөвлөгдж байна. | -                              | 30.0 |
| Зорилт 3. “Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт болон хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-<br>шинжилгээ хийж, нэгтгэн дүгнэх, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт хийх” |   |  |   |  |   |                                |      |
| 11.  | Арга хэмжээ 3.1.<br>Аймгийн хөгжлийн жилийн<br>төлөвлөгөөний хэрэгжилт<br>үр дүнд хяналт-шинжилгээ,<br>үнэлгээ хийж, холбогдох  | -Шалгуур<br>үзүүлэлтийн<br>хэрэгжилтийг<br>бүрэн хангаж<br>ажилласан эсэх  | Аймгийн 2023<br>оны хөгжлийн<br>жилийн<br>төлөвлөгөөни<br>й нийт 112<br>заалтын                   | --   | Аймгийн 2024<br>оны<br>хөгжлийн<br>төлөвлөгөөний<br>биелэлтэд<br>хяналт-<br>шинжилгээ, үнэлгээ хийж,<br>үр дунг аймгийн иргэдийн  | 12/01-05                       | 90.0 |

|     |  |  |   |   |   |             |       |
|-----|--|--|---|---|---|-------------|-------|
|     | байгууллагад тайлагнах, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд байршуулах | -Тайланг журмын дагуу хугацаандаа тайлагнасан байдал                     | биелэлт, үр дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж, хэлэлцүүлэн 94.1 хувийн хэрэгжилттэйг ээр үнэлэгдсэн.                               |   | Төлөөлөгчдийн Хуралд хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.  |             |       |
| 12. | Арга хэмжээ 3.2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх           | -Хяналт-шинжилгээ хийгдсэн эсэх<br>-Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 үндсэн чиглэлийн хүрээнд 26 зорилт, 54 арга хэмжээтэйгээр төлөвлөн, 96.8 хувийн хэрэгжилттэйг ээр дүгнэгдсэн. | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ хийж ажилласан байна. | Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт 2024 оны 1 дүгээр улиралд хүргүүлж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд хугацаанд нь байршуулж ажилласан. Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 96.8 хувийн хэрэгжилттэйгээр дүгнэж хүргүүлсэн бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас 75.1 хувийн хэрэгжилттэйгээр дүгнэж, холбогдох зөвлөмжийг ирүүлсэн. | 01/05-12/05 | 100.0 |

|     |   |   |   |   |  |             |       |
|-----|---|---|---|---|--|-------------|-------|
|     |   |   |   |   | Bайгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэж байна.  |             |       |
| 13. | Арга хэмжээ 3.3.<br><br>3-аас доошгүй сумдын Засаг даргын 2024 оны захирамжид хяналт-шинжилгээ хийж, зөвлөмж хүргүүлэх                      | -Хамрагдсан сумын тоо<br>-Хяналт-шинжилгээ хийсэн захирамжийн тоо<br>-Хүргүүлсэн зөвлөмжийн тоо | Сант, Баянгол, Тарагт, Зүүнбаян-Улаан сумдын 2023 оны 6-9 дүгээр сард гарсан нийт 424 захирамжид хяналт-шинжилгээ хийсэн. | --  | Аймгийн Засаг даргын 2024 оны эхний хагас жилд гаргасан захирамжид хяналт-шинжилгээ хийгдэж байна.   | 11/10-12/05 | 50.0  |
| 14. | Арга хэмжээ 3.4.<br><br>Байгууллагын дотоод хяналтын нэгжийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг хангаж ажиллах | -Төлөвлөгөө боловсруулагдсан эсэх<br>-Хэрэгжилтийг дүгнэж ажилласан байдал                      | --  | Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан байна. | Дотоод хяналтын нэгжийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг ажлын хэсгийн гишүүдээс санал авч, боловсруулан ажиллалаа. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт тайланг хүргүүлж ажилласан. Засгийн газрын Хяналт-хэрэгжүүлэх газрын Хяналт шалгалтын багийн ахлах шинжээч Ц.Идэрбат тус хэлтэст ажиллаж, байгууллагын дотоод хяналтын нэгжийн үйл | 03/01-6/30  | 100.0 |

|     |   |   |   |   |   |             |      |
|-----|---|---|---|---|---|-------------|------|
|     |   |   |   | ажиллагаатай танилцаж, арга зүйн зөвлөмж өгч ажиллалаа. |   |             |      |
| 15. | Арга хэмжээ № 3.5.<br>Засаг даргын Тамгын газарт чанарын менежментийн тогтолцоо нь ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх | -Стандарт шаардлагуудын дагуу баримт бичгийн бүрдлийг хангасан байдал<br>-Чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлсэн байдал | -Стандарт шаардлагуудын дагуу баримт бичгийн бүрдлийг хангасан байдал<br>-Чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлсэн байдал | Холбогдох дүрэм, журмыг баталгаажуулан ажилласан байна. | Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай 8 журмыг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж, зөвлөх багийн арга зүйн зөвлөмжийн хүрээнд ажилласан. | 02/01-11/10 | 70.0 |

**Зорилт 3. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах”**

|  |  |  |  |   |  |             |       |
|--|--|--|--|---|--|-------------|-------|
|  | Арга хэмжээ № 4.1<br><br>Хариуцсан ажлын байрны чиг үүргийн хүрээнд албан үүргээ хууль тогтоомжоор хүлээсэн эрх, үүргийн хэмжээнд бүрэн ханган биелүүлэх<br><br>- Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр заасан хугацаанд хийж гүйцэтгэн, хурал цуглаан, сургалт семинар, арга хэмжээнд оролцох<br><br>- Төрийн албаны тухай хууль болон бусад төрийн албан хаагчтай | -Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоогоор<br><br>-Хэлтсээс гаргасан мэдээ мэдээллийн тоогоор | Удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгавар, холбогдох мэдээ тайланг хугацаанд гаргаж, биелэлтийг тооцон ажилласан. | Үйл ажиллагааны хэрэгжилтийг бүрэн хангаж, шаардлагатай мэдээллээр удирдлага болон холбогдох албан байгууллагыг хангаж ажилласан байна. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад арга зүйн зөвлөмж өгч ажиллав.<br><br>Байгууллагын хэмжээнд зохион байгуулагдсан цаг үеийн чанартай ажлуудад оролцож, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн ажилласан. | 01/02-12/05 | 100.0 |
|--|--|--|--|---|--|-------------|-------|

|     |  |  |  |   |   |            |       |
|-----|--|--|--|---|---|------------|-------|
|     | холбогдолтой хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд ажиллаж, төрийн албан хаагчийн ёс зүйг чанд баримтлан, хүнд суртал чирэгдэлгүй, авилгаас ангид байх<br><br>Хэлтсийн үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээх |  |  |   |   |            |       |
| 17. | Арга хэмжээ № 4.2<br><br>Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг хангах, хөтлөн явуулах<br><br>Байгууллагын архивын баримт бичгийг холбогдох архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу архивт шилжүүлэх              | -Хугацаанд нь шилжүүлсэн эсэх<br><br>-Баримтын бүрдлийг хангасан эсэх  | Журмын дагуу баримтыг хугацаанд нь шилжүүлэн ажилласан.  |   | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу баримтын бүрдлийг ханган, албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу архивт хугацаанд нь шилжүүлэн ажилласан. | 04/01-4/30 | 100.0 |
| 18. | Арга хэмжээ № 4.3<br><br>Шинээр батлагдсан дүрэм, журам шийдвэрийн талаар албан хаагчдад арга зүйн сургалтыг зохион байгуулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх   | -Зохион байгуулсан сургалтын тоо<br><br>-Хамрагдсан албан хаагчдын тоо | 5-аас доошгүй удаагийн сургалтыг зохион байгуулж, 150-аас доошгүй албан хаагчийг хамруулсан байна. | Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээнд анхаарах асуудлын талаар сургалт, мэдээлэл хийж ажиллав. Уг үйл ажиллагаанд нийт 40 орчим албан хаагчид хамрагдav. Соёлын байгууллагын удирдах албан тушаалтан болон сумдын төсөвт байгууллагуудын бичиг | 02/22-11/30   | 100.0      |       |

|  |  |  |  |  |   |  |  |
|--|--|--|--|--|---|--|--|
|  |  |  |  |  | хэргийн ажилтан, хууль эрх зүйн мэргэжилтнүүдэд зориулсан сургалтын үеэр хяналт-шинжилгээ, үнэлгээ анхаарах асуудлын талаар мэдээлэл хийж ажилласан. Дээрх сургалтын үйл ажиллагаанд нийт 80 орчим албан хаагчид хамрагдсан байна. Мөн санхүүгийн байгууллагын албан хаагчдын нэгдсэн уулзалт, хэлэлцүүлэгт оролцож хяналт-шинжилгээ, үнэлгээний талаарх холбогдох мэдээллийг өгч, харилцан мэдээлэл солилцтоо. |  |  |
|--|--|--|--|--|---|--|--|

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

| Д/д | Үүрэг даалгавар<br>(арга хэмжээ)  | Шалгуур<br>үзүүлэлт                                  | Суурь<br>түвшин | Хүрэх түвшин   | Хүрсэн түвшин (биелэлт)  | Эхэлсэн,<br>дууссан<br>хугацаа | Биелэлт<br>ийн хувь |
|-----|---|--|-----------------|--|--|--------------------------------|---------------------|
| 1.  | Үүрэг даалгавар (арга хэмжээ)<br>1.<br>Сумын багийн дарга нарын сургалтыг зохион байгуулах ажлын хэсэгт ажиллах | Үйл ажиллагааны тоо<br>Хамрагдсан албан хаагчдын тоо | -               | Аймгийн 113 багийн дарга нарыг хамруулсан байна.<br>Сургалт үйл ажиллагааны бэлтгэлийг хангуулсан байна. | 2024 оны 3 дугаар сарын 4-5-ний өдрүүдэд зохион байгуулсан багийн Засаг даргын нарыг чадавхжуулах сургалт зохион байгуулах ажлын хэсэгт орж, А заалыг хариуцан зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллав. | 3/04-05                        | 100.0               |
| 2.  | Үүрэг даалгавар (арга хэмжээ)<br>2.<br>“Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” бодлогын баримт                      | Өгөгдсөн хугацаанд бүрэн тайлагнасан эсэх            | -               | Маягтын дагуу тайланг нэгтгэн дүгнэж холбогдох дээд  | Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын талаарх хууль болон Улсын Их Хурлын тогтоол нийт 31 заалт бүхий  | 1/31                           | 100.0               |

|    |  |   |   |   |   |       |       |
|----|--|---|---|---|---|-------|-------|
|    | бичгийн тайлагнах  | хэрэгжилтийг  |   | шатны байгууллагад тайлагнасан байна.   | шийдвэрийн хэрэгжилт, үр дүнг нэгтгэн дүгнэж Орхон, Архангай, Баянхонгор, Хөвсгөл аймгуудаас авч нэгтгэн Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хугацаанд нь тайлагнав.   |       |       |
| 3. | Үүрэг даалгавар (арга хэмжээ)<br>3.<br>Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас зохион байгуулсан сургалт хэлэлцүүлгийн арга хэмжээ   | Сургалт арга хэмжээнд оролцсон байгууллагуудын оролцооны түвшин | - | Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, орон нутгийн өмчит хуулийн этгээд нийт 70-аас доошгүй албан хаагч | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлгийн арга хэмжээнд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод хяналтын чиг үүрэг гүйцэтгэгч албан тушаалтнууд, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын төлөөлөл нийт 75 албан хаагчдыг хамруулав. | 11/08 | 100.0 |
| 4. | Үүрэг даалгавар (арга хэмжээ)<br>4.<br>Мониторинг хийх нийтлэг журам, Үнэлгээ хийх нийтлэг журам, Төрийн байгууллагын гүйцэтгэлийн удирдлагыг дүгнэх журмын төсөлд санал хүргүүлэх | Гарсан саналын тоогоор  | - | Гарсан саналыг шаардлагатай хугацаанд ХХГазарт хүргүүлнэ  | Мониторинг хийх нийтлэг журам, Үнэлгээ хийх нийтлэг журам, Төрийн байгууллагын гүйцэтгэлийн удирдлагыг дүгнэх журмуудын төсөлд холбогдох орон нутгийн байгууллага, албан тушаалтнуудаас ирүүлсэн саналыг нэгтгэн Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хугацаанд нь хүргүүлж ажилласан.  | 11/15 | 100.0 |

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ  | Шалгуур ҮЗҮҮЛЭЛТ                       | Гүйцэтгэлийн түвшин               |  |   |                          |                  |
|-----|---|--|-----------------------------------|--|---|--------------------------|------------------|
|     |   |  | Суурь түвшин                      | Хүрэх түвшин   | Хүрсэн түвшин (биелэлт)   | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл тийн хувь |
| 1   | 2   | 3                                      | 4                                 | 5  | 6   | 7                        |                  |
| 1.  | Арга хэмжээ 1.<br>Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр гадаад, дотоодын байгууллагуудаас харилцан туршлага судлах | Туршлага судалсан байгууллагын тоогоор | --                                | Дотоодын 1 байгууллагын үйл ажиллагааны туршлага судалсан байна. | Төв болон Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэстэй хамтран ажиллаж, цахим уулзалтыг зохион байгуулан харилцан туршлага солилцлоо.  | 11/01-11/05              | 30.0             |
| 2.  | Арга хэмжээ 2.<br>Шинээр мөрдөгдөж байгаа дүрэм, журам, хуулийн шинэчлэлтэй танилцаж, судлах                        | Судалж танилцсан дүрэм журмын тоогоор  | 2 хууль, 4 дүрэм журмыг судалсан. | 2-оос доошгүй дүрэм журамтай танилцах.                           | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын "Аргачлал загвар батлах тухай" 98 дугаар тушаал зэрэг шинээр мөрдөгдөж байгаа 8 журамтай танилцлаа. мөн эрүүл мэндийн чиглэлээр 2 удаагийн, үйл ажиллагааны хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэхэд чиглэсэн 4 удаагийн сургалт, 7 хоног бүр зохион байгуулагддаг 7:4:10 төрийн албан хаагчдад зориулсан сургалт үйл ажиллагаанд тогтмол хамрагдаж байна. Удирдлагын академийн ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад хамрагдаж байна. | 01/02-12/05              | 100.0            |

|    |   |                     |                        |  |   |             |       |
|----|---|---------------------|------------------------|--|---|-------------|-------|
| 3. | Арга хэмжээ 3.<br>Гадаад хэлний мэдлэгээ нэмэгдүүлэх                              | Мэдлэгийн түвшинээр | Анхан шатны мэдлэгтэй. | Англи хэлний мэдлэгийн түвшинг нэмэгдүүлсэн байна. | Бие даан өдөр бүр 5-аас доошгүй үг шинээр цээжилж, англи хэл дээр кино үзэж хэлний мэдлэгийн түвшнээ ахиулахад байна. | 01/02-12/05 | 100.0 |
| 4. | Арга хэмжээ 4.<br>Монгол бичгийн мэдлэгээ нэмэгдүүлэх чиглэлээр бие даан суралцах | Мэдлэгийн түвшинээр | Дунд шатны мэдлэгтэй.  | Мэдлэгийн түвшинг нэмэгдүүлсэн байна.              | Бие даан суралцаж, монгол бичгээр унших, бичиг дадлагыг 7 хоногт 2-оос доошгүй цагийг зарцуулж байна.                 | 01/02-12/05 | 100.0 |

## ТАЙЛАН ГАРГАСАН:

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт  
хариуцсан ахлах мэргэжилтэн



/ Л.Ишханд/

2024.12.05